



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

### “Монгол хувьцаа ҮЦК” ХХК-ийн гишүүнчлэлийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.9, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.27 “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 459 дүгээр тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол хувьцаа ҮЦК” ХХК-ийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнчлэлээс хассан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.
2. Тогтоолыг хүчингүй болгосонтой холбогдуулан мэдээллийн санд зохих өөрчлөлт оруулах, олон нийтэд мэдээлэх, “Гишүүнчлэлийн гэрээ” байгуулах, үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгохыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-т үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “Монгол хувьцаа ҮЦК” ХХК (Г.Баянжаргал)-д үүрэг болгосугай.
4. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн гишүүн үнэт цаасны компанийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1524010111



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

### Гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтын тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.18, 83 дугаар зүйлийн 83.15, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.5.1, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.4, Засгийн газрын хуралдааны 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 38 дугаар тэмдэглэл, Сангийн яамны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/1123 дугаар албан бичиг, 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 01/7957 дугаар албан бичиг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 47 дугаар тогтоолоор зарласан Гүйцэтгэх захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг цуцалж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, үйл ажиллагааг сайжруулж, компанийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлого баримталж гадаад, дотоодын мэргэжлийн удирдлагын баг оролцох боломжийг бүрдүүлэх зорилгоор дахин зохион байгуулсугай.
2. Гүйцэтгэх захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг цуцалсан талаарх мэдээллийг нэр дэвшигчдэд хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Тэмүүжин)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, тухай бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг Нэр дэвшүүлэх хороо (Н.Отгончимэг)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯА

1524010112